

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2019.12.12, №11 (127)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com

WEEKLY



ДеФакто **НИЙТЛЭЛ**
№507

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

Геополитикийн салхи МОНГОЛД



БОЛОВСРОЛ

Б.Насанбаяр
Ph.D /Боловсрол судлал/

Хөгжлийн ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

IV НҮҮРТ

ДеФакто **ТОЙМ**


➤ МУ-ЫН ЕРӨНХИЙ САЙДЫН
ОХУ-Д ХИЙСЭН АЙЛЧЛАЛЫН
ҮР ДҮН

➤ ДИЖИТАЛ МОНГОЛ ХӨТӨЛБӨР
ХЭРЭГЖИХ БОЛОМЖТОЙ ЮУ?

➤ ТӨВ ЦЭНГЭЛДЭХ ХҮРЭЭЛЭНГ
ХУВЬЧЛАХ НЬ ЗӨВ ҮҮ?

VI НҮҮРТ

Геополитикийн салхи МОНГОЛД



Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 2019 оны 12-р сарын 3-6-нд ОХУ-д албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын үеэр олон уулзалт болж, баримт бичгүүдэд гарын үсэг зурснаас байгалийн хийн хоолойг монголоор дамжуулах болсныг энд онцолж байна. Энэ тухай санамж бичигт айлчлалын үеэр Шадар сайд Ө.Энхтүвшин, ОХУ-ын төрийн өмчийн “Газпром” компанийн гүйцэтгэх захирал А.Б.Миллер нар Москвад гарын үсэг зурав. Энэ өдөр бас байгалийн хий дамжуулах “Сибирийн хүч-1” хоолойн албан ёсны нээлт болов.

Орос Хятадын хооронд байгалийн хийн хоолойг нутгаараа дамжуулах хүсэлтээ монголчууд сүүлийн хориод жил тавьж ирсэн ч, саяхан болтол нааштай хариу аваагүй билээ. Тэгвэл яагаад хоёр хөршийн удирдлага ийм шийдвэр гаргах болов оо? Энэ бол геополитикийн салхи хөршүүдийг хамгийн дөт, бартаагүй, талын замыг сонгоход хүргэсэн явдал.

ОРОСЫН ӨӨР ГАРЦ

Орос эдүгээ дэлхийн байгалийн хийн нөөцийн 20 хувь, үйлдвэрлэлийн 17.3 хувийг эзэлдэг, дэлхийн хамгийн том хий экспортлогч орон. Европын, хоолойгоор импортлож буй байгалийн хийн тавны нэгийг Орос нийлүүлж иржээ. Оросын экспортын орлогын 63 хувь, холбооны төсвийн орлогын тал нь газрын тос, байгалийн хийнээс бүтдэг.



▶ 2014 онд Крымийн хойгийг эзлэн авснаас болж АНУ тэргүүтэй барууны орнуудын хориг Орос улсыг экспортын энэ том зах зээлээ бууруулах эрсдэлд оруулаад байгаа. Украйнаар 1240 км урт хоолойгоор, жилд 142 тэрбум шоо метр хий дамжуулж ирсэн ч, улс төрийн эрсдэл нь улам бүр өссөөр. Энэ чиглэлээ орлуулахаар Балтын тэнгисийн гүнээр Герман, Европын бусад оронд хүрэх, жилд 55 тэрбум шоо метр хий дамжуулах хоолой (Умардын урсгал-2) ирэх оны дундуур нээгдэх боловч олон улсын хоригтой тулгарсаар байна. Ерөнхийлөгч В.Зеленский барууны орнууд Оросын эсрэг хориггоо Украин газар нутгаа эргүүлэн автал үргэлжлүүлэхээ амалсан гэж саяхан мэдэгджээ.

Зүүн Европын орнуудыг замдаа хангаж Станбул хүрэх Туркийн урсгал ирэх оны эхээр нээгдэнэ. 1100 км урт, жилд 31.5 тэрбум шоо метр байгалийн хийг Болгар, Серб, Унгар, Словак зэрэг хэд хэдэн улсад нийлүүлэх энэ урсгал, АНУ-ын шингэрүүлсэн хийнээс хямд, барууны хоригт харьцангуй бага өртөх хүлээлттэй байна.

Европтой өрсөлдөхүйц Ази, юуны өмнө дэлхийн хамгийн том зах зээл Хятадад байгалийн хий

нийлүүлэх төслийг (Сибирийн хүч-1) мөн 2014 онд эхлүүлсэн. Намаг, шавар, мөнх цэвдэгтэй Сибирийн тайгаар Хятадын хил хүртэл 3000 км урт хоолой тавьж, Шанхайгаас татсан 3500 км урт хоолойтой холбосон энэ том төсөл саяхан нээгдэв. Ирэх таван жилдээ жигдрүүлсээр, 2025 оноос жилд 38 тэрбум шоо метр хийг 30 жилийн турш нийлүүлэх, 400 тэрбум долларын гэрээ ийнхүү хэрэгжиж эхэллээ. Газпром хоолой барих зардлаа 55 тэрбум доллар гэж тооцсон ч, дийлэнх ажил, материалаа Оросын компаниудаар хийлгэсэн, рублийн ханш унасан зэргээс бодит зардал нь 29 тэрбум доллар болсон гэж Оксфордын Эрчим хүчний судлаачид мэдэгджээ.

.....
Орос Европын зах зээлийн эрсдлээ хаахын тулд Ази руу аль болох их байгалийн хий нийлүүлэх өөр гарц идэвхтэй хайх шаардлагатай болжээ. “Европ, Хятадын хооронд өрсөлдөөн бий болгох үүднээс” ... “Алтайн төслийн оронд “Сибирийн хүч-2” хоолойг монголоор дамжуулна” гэж Үндэсний эрчим хүчний аюулгүй байдлын сангийн дэд дарга А.Гривич (Рос.Газета.19.12.05) хэлжээ.
.....

ХЯТАДЫН ДАВХАР СТРАТЕГИ

Оросын хувьд Ази, юуны өмнө Хятад бол хамгийн боломжтой зах зээл. Хятадын байгалийн хийн хэрэгцээ сүүлийн хоёр жилд 33 хувь өсч, 2024 онд дэлхийн хийн хэрэгцээний өсөлтийн 40 хувийг бүрдүүлэх аж. Тийм ч учраас Оростой улам ойртож, дээрх том гэрээг байгуулсан юм. Гэвч энэхүү “Сибирийн хүч-1” төсөл бүрэн хүчин чадалдаа хүрэхэд Хятадын шингэрүүлсэн хийн жилийн импортын зөвхөн 20 хувийг л эзлэх юм.

The Japan Times (19.12.05) сонин Хятад Оросын хийн түншлэл Японд нөлөөлнө. Оросын байгалийн хий

бусад бүх нийлүүлэгчдээс хямд учир дэлхийн эрчим хүчний зах зээлийн үнийг багасгаж, худалдааны маршрутыг өөрчилнө. Хятадын уламжлалт нийлүүлэгч Австрали бизнесээ алдана, харин урт хугацаандаа Японд ашигтай болно гэжээ. Энэ түншлэл худалдааны эргэлт нь удалгүй 200 тэрбум доллар хүрэхэд нөлөөлөх ажээ. Стратегийн хувьд энэ түншлэл АНУ-ын нөлөөг багасгах зорилготой гэжээ. Тэгээд ч худалдааны дайнаас үүдэн Хятад АНУ-аас авдаг шингэрүүлсэн хийн татвараа 10 хувиас 25 хүртэл энэ оны 6-р сараас өсгөсөн. Өнгөрсөн


онд авсан 2.5 тэрбум шоо метр хийн хэмжээ 2019 онд буурах ажээ. Нүүрсний хэрэглээг багасгах шаардлагын дагуу Энэтхэг, Зүүн Өмнөд Азийн орнуудын байгалийн хийн хэрэгцээ өсөх хандлагатай бөгөөд Хятадын хийн хоолойн өргөн сүлжээнд холбогдох цаг ирэх өндөр магадлалтай. Тэртохиолдолд Хятад улс Оросын байгалийн хийг дамжуулан экспортлох боломж, шаардлага үүснэ.

Байгалийн хийг хоолойгоор татах сүлжээ өргөсөхийн хэрээр шингэрүүлсэн хийн худалдаа буурах хандлагатай болж байна. ▶▶

EAST ASIA AND LNG DOMINATE FUTURE GAS TRADE

UTS:ACRI
AUSTRALIA-CHINA RELATIONS INSTITUTE
澳大利亚-中国关系研究院

Change in gas imports by selected region and mode in the New Policies Scenario, 2016-2040



Asia leads the growth in global gas trade; outside China, new pipeline trade routes find it hard to advance in a market with LNG readily and flexibly available

МОНГОЛЫН ШИНЭ СОРИЛТ

- Ийнхүү эдүгээ бий болсон геополитикийн бодит байдал өмнө нь хийн хоолойг өөр улсаар дамжуулахаас татгалзаж байсан Хятадын бодлогод өөрчлөлт оруулав. Оросууд ч бас өндөр уулсыг дамжуулан их зардлаар, өөрийн хийн нөөц их, дундад азийн хийн хоолой дайрч буй Урумчид хүрэх Алтайн замыг биш, уул намаг байхгүй, Бээжингийн том хэрэглэгчид хүрэх хамгийн дөт зам буюу Монголын, талын замыг сонгоход хүрээд байна.

Хоёр засгийн газар хамтран эзэмшдэг УБТЗ-ын гол шугамын дагуу буюу 1060 км урттай барихаар

тохиролцоод байгаа хийн хоолойн зургийг нарийвчлан гаргах, техник эдийн засгийн тооцоог хоёр жилд багтааж хийгээд, дараа нь 4 жилийн дотор барьж дуусгах боломжтой гэж Оросын "VYGON Consulting" компанийн Д.Акишин (Коммерсантъ. 19.12.04) хэлжээ. 100 мянган км урт хоолой тавьсан туршлагатай Газпром компанид энэ бол бэрхшээлтэй төсөл биш. Харин Орос, Хятад хоёр үнээ тохирно, Монгол улс нутгаараа дамжуулсны төлбөрийг доллараар болон хийгээр авах болно. Монголын хил хүрэх замдаа Эрхүү мужийг хийгээр хангана.

Монголын нутгаар дамжин

жилд 38 тэрбум шоо метр хий дамжуулах чадвартай дан хоолой манай эдийн засагт ямар нөлөөтэй болохыг *"Хийн хоолойн эдийн засаг монголын талд байна"* гэдэг жилийн өмнө бичсэн нийтлэлээс уншина уу. Монголын нутгаар хийн хоолой дамжих нь техникийн асуудал болоод байна. Бүх шийдвэр гарсан, хоолойг барих нь бүх талд, бүх талаараа ашигтай. Ганцхан энэ том төсөл монголын төр засгийн ил тод биш, авлигад хүлэгдсэн улс төрчдийн өрсөлдөөнөөс болоод 5-р цахилгаан станцын төсөл шиг 10 удаа шавыг нь тавиад алга битгий л болчихоосой.

2019.12.11



НИЙТЛЭЛ

Б.НАСАНБАЯР
Ph.D /Боловсрол судлал/

Хөгжлийн

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Миний ашиг сонирхол ирээдүйд бий.

Учир нь би тэнд үлдсэн амьдралаа өнгөрцүлнэ.

Чарлез Кеттеринг

ИХ ДЭЭД СУРГУУЛИУДЫН САНХҮҮЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Төрийн болон төрийн бус өмчийн их, дээд сургуулиудын санхүүжилтийн эх үүсвэрийн 90 гаруй хувь нь оюутны сургалтын төлбөрөөс шууд хамааралтай байсаар өдийг хүрлээ. Манай ихэнх их дээд сургуулийн сургалтын төлбөр маш бага, дээд боловсролын байгууллагын багш, судлаач, ажиллагсдын цалин тааруу байна. Чанартай дээд боловсролыг ийм бага төлбөрөөр хүргэж байгаа нь “гайхамшигтай” хэдий ч цаашид энэ байдал үргэлжилснээр чанар, үр дүнг сайжруулах ямар ч боломжгүй. Гэтэл одоогийн эрх баригчид “Төрийн өмчийн 8 их сургуулийг нэгтгэнэ” гэхээс өөр шийдэл ярьсан зүйл алга.

Дээд боловсролын салбарын хөрөнгө оруулалтын үр шимийг зөвхөн боловсролын салбарын хүрээнд харах нь эндүүрэл. Ургац хураахын тулд үр суулгахтай адилаар ирээдүйд өгөөжөө өгч хувь хүний орлого, үндэсний хөгжил болно гэдгийг хүлээн зөвшөөрөх нь хөгжлийн түлхүүр юм.

Гэтэл одоогийн Засгийн газар бүр эсрэгээрээ төрийн өмчийн дээд боловсролын байгууллагын барилга байшингийн ашиглалтын урсгал зардлыг 2018 оноос улсын төсвөөс олгохоо зогсоов. Энэ тухай УИХ-ын даргын зөвлөх Д.Бадарч гуай тайлбарлахдаа “Манай их сургуулиудын буруугаас болсон. Тэдний данс их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй байсан учир хассан” гэжээ. Төрөөс хөрөнгө оруулалт бараг байхгүй хэдий ч сургуулиуд өөрсдийн олсон бүхий л орлогыг тухайн жилд зарцуулж дуусгах ёстой гэсэн үрэлгэн “гажиг” шаардлагыг ойлгох аргагүй. Төрийн бус өмчийн буюу хувийн хэвшлийн их дээд сургуулиудыг дэмжих, урамшуулах бодлого чиглэл бүр огт алга. Гэтэл өнөөгийн дэлхийн шилдэг 100 их сургуулийн эхний аравт хувийн хэвшлийн сургуулиуд жагсаж, дэлхийг дагуулж байна.

Судлаач, профессор Жамил Салми, Кай Мин Чен нарын “Монгол улсад дээд боловсролын тогтвортой санхүүжилтийн

стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх бодлогын арга зам” сэдэвт зөвлөмжид: “...Монгол улс дээд боловсролд зориулах төсвийн санхүүжилтийг одоогоор зөвхөн барилга байшингийн ашиглалтын урсгал зардлыг (2018 оноос олгохоо больсон) төлөхөөр хязгаарлаж байна. Их сургуулиудын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг улс орны хувьд өндөр ач холбогдолтой цөөн чиглэлд төвлөрүүлэн хөрөнгө оруулалт хийхэд ихээхэн анхаарах ёстой. Боловсролын яам болон Сангийн яам нь дээд боловсролын эрэлт хэрэгцээг хангахад хүрэлцэхүйц санхүүжилтийг баталгаажуулсан санхүүгийн загварыг тохиролцох шаардлагатай. Олон улсын туршлагаас үзэхэд, дээд боловсролд улсын төсвөөс зарцуулах хөрөнгийн хэмжээ ДНБ-ий нэг хувиас илүү гарч байж үр дүнд хүрдэг. Ийм хэмжээний санхүүжилтэд ойрын таван жилийн хугацаанд шат дараатайгаар хүрэх үүрэг зорилттой байвал зохилтой” гэжээ.

САНХҮҮЖИЛТИЙН ШИЙДЭЛ

Монголын их дээд сургуулиуд ирээдүйд хандив, гэрээт судалгаа, зөвлөх үйлчилгээ, боловсролын хөтөлбөр зэрэг орлого олох, хөрөнгө босгох бусад эх үүсвэрийг дайчлахад суралцах нь гарцаагүй. Гэвч Монгол улсын Засгийн газар Үндэсний хөгжлийн бодлогын зорилтод нийцсэн дээд боловсролын салбарт ажлын үр дүнг урамшуулах, гүйцэтгэлд суурилсан төсвийн хуваарилалтын механизмыг нэвтрүүлэх шаардлагатай. Дараах 4 төрлийн санхүүжилтийн механизмаас тохирох шийдлийг сонгон ашиглаж болох юм. Үүнд:

- 1. ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТ.** Явцын эсвэл эцсийн үр дүнгийн үзүүлэлтийг санхүүжилтийн хэмжээг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн тодорхойлох суурь болгоно. Энэ томъёоллыг хэрэглэдэг Дани улс шалгалтаа амжилттай өгсөн оюутны тоог үндэслэн урсгал зардлын 30-50 хувийг “taximeter загвар”-аар, Голланд боловсролын зэрэг (диплом) авсан төгсөгчдийн тоонд үндэслэн урсгал зардлын тал хувьтай тэнцэх хэмжээтэй, Австрали докторантын төгсөлт (40%), судалгааны үр дүн (10%), өрсөлдөөнт төсөлд шалгарсан ажлыг оролцуулан судалгааны ажлаас олсон орлогын (50%)-ыг тус тус тооцон санхүүжилт олгодог байна.
- 2. ГҮЙЦЭТГЭЛИЙН ГЭРЭЭ.** Засгийн газар дээд боловсролын байгууллагатай гүйцэтгэлд суурилсан зорилгыг тодорхойлсон зохицуулалтын гэрээ байгуулна. Энэ гэрээнд дээд боловсролын байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтийг тусгадаг бөгөөд үүнтэй холбоотойгоор шаардагдах нэмэлт санхүүжилт хийх үндэслэл болдог. Тухайн боловсролын байгууллага нь гэрээний нөхцлийг хэрхэн хангасныг үндэслэсэн санхүүжилтийг бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн олгож болно. Гүйцэтгэлийн гэрээ ашигладаг Франц улс 1989 оноос хойш урсгал төсвийн 30-50 хүртэл хувийг 4 жилийн хугацаатай гүйцэтгэлийн гэрээгээр олгож байна. Финлянд дээд боловсролын ерөнхий зорилго болон тухайн сургуулийн тодорхой зорилгыг тодорхойлсон гэрээ байдаг. Дани тухайн сургуулийг урт хугацаанд сайжруулах зорилгыг илэрхийлсэн “хөгжлийн гэрээ” байгуулдаг. Чили “гүйцэтгэлийн гэрээ”-г улсын 4 их сургуультай туршилтын журмаар нэвтрүүлж байна. Энэ улс орнууд их сургуулиудтайгаа хүрэх түвшин, ахиц дэвшлээ тодорхой тусгасан хөгжлийн зорилтуудаа нарийвчлан тохиролцож, үүнтэй уялдсан нэмэлт санхүүжилтийн тогтолцоо хэрэгжүүлж байна.
- 3. ӨРСӨЛДӨӨНТ САНХҮҮЖИЛТ.** Өрсөлдөөнт санхүүжилт нь боловсролын байгууллагуудын бэлтгэж ирүүлсэн төслийг нийтэд ил тод шалгуур, журмаар мэргэжлийн хараат бус гишүүдээс бүрдсэн зөвлөл шүүж шалгаруулдаг. Улс орнуудын хөгжлийн бодлогын онцлогоос хамааран тавигдах шалгуур, чиглэл нь ялгаатай байдаг. Жишээ нь Аргентин, Индонез улсад өрсөлдөөнт санхүүжилт горилсон төслийг их дээд сургууль бүхэлдээ, эсвэл аль нэг факультет, тэнхим бэлтгэн ирүүлж болдог. Чилид улсын, хувийн аль ч сургууль өрсөлдөх эрхтэй байдаг. Египетэд 1990-ээд оноос эхлэн инженерийн салбарын шинэчлэлийг дэмжих зорилготой өрсөлдөөнт санхүүжилтийн тусгай сан байгуулсан байна. Өрсөлдөөнт санхүүжилтийг нэвтрүүлэхийн хамгийн чухал үр дүн нь сонгон шалгаруулалтад шударга, ил тод, журам тогтож, үнэлгээний бие даасан хараат бус жишиг бий болдог. Өрсөлдөөнт санхүүжилтийн механизмын өөр нэг ашигтай тал нь их сургуулиуд эрэлт хэрэгцээг сайтар тодотгож, үйл ажиллагаагаа нарийвчлан төлөвлөсний үндсэн дээр хэрэгжүүлэх төслийн саналаа боловсруулан, стратеги төлөвлөлтийн туршлагаа сайжруулдаг.
- 4. ВАУЧЕР.** Оюутнуудад аль ч дээд боловсролын байгууллагыг сонгон төлбөртөө ашиглаж болох мөнгөний хэмжээг илтгэсэн купон олгоно. Ваучераар санхүүжүүлэхийн зорилго нь төрийн дэмжлэгийг боловсролын байгууллагуудад хэрэглэгчээр нь дамжуулан шууд бус байдлаар олгон, оюутны хүсэл сонирхолд нийцсэн үйлчилгээ үзүүлэхийн төлөөх дээд боловсролын байгууллагуудын өрсөлдөөнийг дэмжихэд (Salmi & Hauptman, 2006) оршино. Оюутнуудад тараасан купоныг урсгал зардлын төлбөрийн хэрэгсэл болгон ашигладаг улс орнууд ч байна. Хамгийн тод жишээг Казахстан, Гүрж, Азербайжан, Литв зэрэг хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнуудын туршлагаас харж болно. Казахстанд оюутнуудын 20 орчим хувь нь боловсролын тэтгэлгийн эрхийн бичгийг авдаг ба энэхүү тэтгэлгийг хувийн болон улсын аль ч сургуульд тухайн тэтгэлэгт хамруулахаар заасан чиглэлээр сонгон суралцахад ашиглах боломжтой.

Дээд боловсролын санхүүжилтийн шинэчлэл нь өөрөө эцсийн зорилго биш, харин дээд боловсролын сургалт, судалгаа, хөтөлбөрийн чанар, үр дүн, хариуцлагыг дээшлүүлж, хөгжлийн тогтвортой байдлыг хангах юм. Иймд дээд боловсролын санхүүжилтийн шинэчлэлийг улс орны хөгжлийн цаашдын бодлого, төлөвлөлтийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг болговол, эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжихэд дээд боловсролын гүйцэтгэх үүрэг илүү тодорхой болно. Боловсролын салбарт зарцуулж буй санхүүжилт бол зардал биш ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ юм.



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.12.08-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

МУ-ЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ОХУ-Д ХИЙСЭН АЙЛЧЛАЛЫН ҮР ДҮН

Энэ айлчлалын хэвлэл мэдээллийн багийн бүрэлдэхүүнд багтах боломж олдсон. Айлчлалын эхний онцлог бол МУ-ын Ерөнхий сайд 9 жилийн дараа ОХУ-д айлчиллаа. Сү.Батболд Ерөнхий сайд байхдаа 2010 онд айлчилж байсан. Дараагийн онцлог бол хоёр хөрштэйгээ иж бүрэн стратегийн түншлэлтэй болсноос хойш Ерөнхий сайдын буюу гүйцэтгэх засаглалын хэмжээний анхны айлчлал болсон. Иж бүрэн стратегийн түншлэл гэдэг бол улс төр, эдийн засаг гээд бүх салбарт харилцаагаа өргөжүүлнэ гэсэн санаа. Гэхдээ бидний харилцаа эдийн засгийнхаа түвшинд үнэхээр хангалтгүй байгаа гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Олон санамж бичигт гарын үсэг зурсан ч, санамж бичиг бол гэрээ биш гэдгийг ойлгох хэрэгтэй.

Евразийн эдийн засгийн холбоотой 2 жилийн турш хамтран



ажиллах гэрээнд гарын үсэг зурсан. Энэ холбоонд Казахстан, Киргизстан, Беларус зэрэг орнууд байдаг ба гишүүн болвол бараа бүтээгдэхүүн хил гаалийн татваргүй харилцан нэвтрэлцэнэ гэсэн үг. Гэхдээ яг ижил бараа татваргүй ороод ирчихвэл, том улсын бараа нэгжийн өртөг нь хямд байдаг учраас монголын жижиг дунд үйлдвэрүүдэд яаж нөлөөлөхийг тооцоолоход хэцүү тул энэ 2 жилд судлах боломжтой гэж харж байна.

ТЭЦ 3,4-ийг шинэчлэнэ гэсэн яриа гарч байсан боловч, энэ асуудлаар тусгайлан яригдаагүй. Төмөр замын талаар ерөнхий зүйлс яригдсан ч бодит ажил болох зүйл яригдаагүй. Мөн ЗХУ-ын эзэмшиж байсан зарим үндсэн хөрөнгийг монголын талд шилжүүлсэн. Энэ удаагийн айлчлалын хамгийн том хүлээлт буюу байгалийн хийн хоолойг монголын нутгаар дайруулах асуудлын тухай бичсэн нийтлэлийг эхний нүүрнээс уншина уу.

ДИЖИТАЛ МОНГОЛ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИХ БОЛОМЖТОЙ ЮУ?

Монгол улсын Засгийн газар “2050 он хүртэлх урт хугацааны хөгжлийн бодлого” нэртэй бодлогын баримт бичгийг боловсруулж байгаа. Тус баримт бичигт төрөөс цахим хөгжлийн асуудлаар ямар бодлого, чиглэл баримтлах талаар хэлэлцүүлэг өрнүүлээ. Энэ хүрээнд “Дижитал Монгол улс” форумыг өнгөрсөн долоо хоногт зохион байгуулсан.

Хүссэн хүсээгүй бидний заавал явах зам л даа. Ашиглаж чадвал цахим ертөнц Монгол шиг цөөн хүн амтай, том нутагтай оронд хөгжлийн түүхэн боломжийг олгож байна. Нөгөө талаас монголчууд бид орчин үеийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн давуу талыг яаралтай ашиглаж эхлэхгүй бол бусад улс орноос улам л хоцрох нь. Бид цахим ертөнцөд нэвтрэн орж, ажил амьдралаа дасган зохицуулж, хүн бүр өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхээс өөр сонголтгүй болчихсон.

Эдүгээ улс орнууд цахим нийгэм бүтээн байгуулж байна. Иргэд нь гэрээсээ гарахгүйгээр сонгуульд саналаа өгч, бүх төрлийн тайлан, мэдээ бэлтгэн, холбогдох маягт, гэрээ хэлцэл дээр гарын үсгээ гар утаснаасаа “зурж” буй. Компания хэдхэн минутын дотор бүртгүүлж, хөрөнгө болон холбогдох хуулийн мэдээллийг гар утсаараа шалгаж, бүтээгдэхүүн, үйлчилгээгээр төр засаг нь баталгаажуулан, интернетээр аюулгүй борлуулж байна. Төр засгийн байгууллагууд бүх түвшинд мэдээллээ холбож, иргэддээ онлайнаар үйлчлэх болсноор хүнд суртал түүх болж эхэлсэн.

Хамгийн өгөөжтэй цахим нийгэм байгуулж буй улсуудын нэг болох Эстонид нийтийн засаглалын ил тод, нээлттэй байдлыг урьд өмнө байгаагүй түвшинд хангаж, хувь хүн, төр засаг,

бизнесийн мэдээллийг аюулгүй байдлын өндөр хамгаалалттай цахим орчинд, хүссэн үедээ солилцох боломж бүрдүүлжээ. Нийгмийн үйлчилгээ хүн бүрт хурдан хүрч, эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх боломж олгосноор хүн амын дундаж нас мэдэгдэхүйц дээшлэв. Боловсролын салбарт ч өөрчлөлт гарч, иргэдийн мэдлэг боловсрол нь дэлхий даяар өрсөлдөх чадвартай болж байна. Технологийн их сургуулиа Мэдлэг дамжуулах төв болгон хөгжүүлж “Ericsson”, “Samsung”-ийн лабораториуд, “Mitsubishi”-гийн цахилгаан автомашины туршилтын төв болгох зэргээр олон шинэ төсөл хэрэгжүүлэн Хойд Европын инженер технологийн авьяастнуудыг цуглуулж байна. Бизнес эрхлэх орчин нь ч сайжирч, мэдлэгийн эдийн засагтай болж, нийгэм, эдийн засгийн хөгжлөөрөө сүүлийн арван жилд Европыг тэргүүлж иржээ.

Монголчууд бид нүүдэлчид, байгалиасаа сониуч зантай, юмны цаад учрыг үргэлж олохыг хичээдэг. Мөн гадаад хэл сурахдаа хурдан, шинэ орчинд дасан зохицохдоо чадварлаг. Гэхдээ энэ бүхэн нь цахим ертөнцийн өргөн боломжийг ашиглахад хангалтгүй. Бидэнд өнөөдөр бизнесийн таатай нөхцөл, шинэ санаачилгыг урамшуулсан орчин, мэдээлэл ба харилцаа холбооны технологийн дэд бүтэц, шударга өрсөлдөөн, түүнийг дэмжсэн төр засгийн ил тод



зохицуулалт шаардлагатай байна.

Монгол улсын хүн амын 45 хувь нь 25 хүртэлх насныхан. Тэдний ихэнх нь тоон ертөнц, гар утас, интернетгүй амьдрал байсныг мэдэхгүй гэхэд хилсдэхгүй. Хүн амаа Англи, Монгол хос хэлтэй болгох, дээр нь бусад гадаад хэл сонгох боломжоор хангаж, мэдээлэл ба харилцаа холбооны технологийн дэд бүтцээ хөгжүүлэн, чадварлагаар ашиглаад эхэлвэл манай улс богино хугацаанд үсрэнгүй хөгжиж болно. Тэгэхийн тулд манай мэдээлэл ба харилцаа холбооны технологийн дэд бүтэц аюулгүй, хувь хүмүүс, бизнес, төр засгийн мэдээ мэдээллийн нууц баталгаатай хамгаалагдсан байх ёстой. Энэ бол аюулгүй байдлын нэрээр интернетийн ашиглалтыг хязгаарлана гэсэн үг биш. Интернетэд холбогдох эрх чөлөө хүн бүрт байх ёстой. Хувийн нууц болон интернетийн эрх чөлөөг хамгаалах нь ардчилсан улс орнуудын өмнө тулгарч буй томоохон сорилт, үсрэнгүй хөгжлийн үндсэн шаардлага болоод байна.

ТӨВ ЦЭНГЭЛДЭХ ХҮРЭЭЛЭНГ ХУВЬЧЛАХ НЬ ЗӨВ ҮҮ?

12-р сарын 2-нд Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит хуралдаан болж Нийслэлийн өмчөөс 2020 онд хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалтыг гаргасан. Уг жагсаалтад Төв цэнгэлдэх хүрээлэн багтсан. Төв цэнгэлдэх хүрээлэнгийн 49 хувь нь нийслэлийн эзэмшилд байдаг.

Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын дарга Ш.Үнэнбат “Засгийн газрын 182 дугаар тогтоолын дагуу нийслэлийн эзэмшлийн нийт 12.7 га газрыг урьдчилсан байдлаар үнэлэхэд 20 тэрбум төгрөгт хүрч байгаа. Энэ бол зөвхөн газрынх нь үнэ. Нийслэлийн Өмч хувьчлалын комисс дахин үнэлгээ хийнэ. Компанийн тухай хуулийн 5.3-т заасны дагуу нийслэлийн Өмч хувьчлалын комисс өөрийн 49 хувийг үнэлэн нэн тэргүүнд 51 хувийг эзэмшиж буй компанид санал болгох ёстой. Санал болгосон үнээр хувь эзэмшигч компани авахгүй бол дуудлага худалдаанд оруулна.” гэж хэлсэн.

Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч Ж.Батбаясгалан “Төв цэнгэлдэх хүрээлэн ашиггүй, зарлага ихтэй. Одоогийн цэнгэлдэхийн багтаамжийг 3-4 дахин нэмэгдүүлэх буюу 35-45 мянган хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн барихаар Засгийн газар шийдвэрлэсэн. Уг ажлыг эхлүүлэх хөрөнгө 2020 оны



төсөвт суусан. Цэнгэлдэхийг худалдсанаар өнгөрсөн хугацаанд гарсан зардлыг хэд дахин нугалах орлого нийслэлийн төсөвт орох боломжтой. Бид зардлаа хэд дахин нугалж олох ийм л зорилго тавьж байна” гэсэн.

Бид хувийн өмчид суурилсан эдийн засгийг бүтээж байгаа. Төв цэнгэлдэх хүрээлэнгийн хувьчлалын хувьд шийдвэр гаргадаг дарга нарын хамааралтай компаниуд л хулгайгаар авчихгүй байхаар зохион байгуулах хэрэгтэй.

*Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв
Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вeбсайтаас үзэх боломжтой.*

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вeбсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com

✉ +976 94109342

🌐 www.defacto.mn

www.jargaldefacto.com